

<sup>17</sup> Лувсанбалдан Х. Тод үсэг, түүний дурсгалууд. Улаанбаатар. 1975. С. 240.

<sup>18</sup> Описание тибетских памятников, относящихся к жанру гимнов-славословий (тиб. *stod-pa*, монг. *maytaal*), было издано нами ранее. См.: Музраева Д.Н. Гимны-славословия из тибетской коллекции КИГИ РАН // Российское монголоведение. Бюллетень 5. М., 2001. С. 266-278.

*С. Намжавин*

### Тод үсгийн түүхийн хөгжлийг үелэн хуваах асуудалд

Тод үсгийн хувирж хөгжсөн түүхийн явцыг анх үелэн хуваасан явдал нь Монгол Улсын нэрт ойродч Х. Лувсанбалдан гуайн нэр лүгээ холбоотой юм. Тэрээр тод үсгийн хувирал хөгжлийн замыг гурван шатад үелэн хуваахдаа, нэгдүгээр үе нь 1648 оноос XVIII зууны 2-р хагас хүртэл, хоёрдугаар үе нь XVIII зууны 2-р хагасаас Халимагт 1924 он хүртэл, Шинжаанд одоо хүртэл гэж тус тус үелэж болно гээд [Х. Лувсанбалдан, 1975. х. 62], цааш нь бас XVIII зууны хоёрдугаар хагасаас одоо хүртэл Шинжаан мужийн монголчуудын хэрэглэж байгаа тод үсэг нь үсэг зүй, авиа зүй, үгийн сангийн талаар жинхэнэ Шинжаангийн Ойрдын аялгууг тусгасан тод үсэг болжээ гэсэн билээ [Х. Лувсанбалдан, 1975. х. 63]. Гэвч Х. Лувсанбалданы саналыг нарийвчлан үзэхэд түүний энэхүү үелэл нь XVIII зууны хоёрдугаар хагас хийгээд одоогийн Шинжаангийн тод үсгийн үнэн байдалтай арай нийцэхгүй байна. Заяа бандидын зохиосон тод үсгийн тогтолцоо нь XIX зууны сүүл үе хүртэл Шинжаанд сонгодог хэв журмаа хадгалсаар байсныг энэ үетэй холбогдох, он цаг нь тодорхой дурсгал бичгийн зүйлс баттай гэрчлэж бий бөгөөд тэр байтугай, 1940 -өөд онд Шинжаанд гарсан «Дайныг эсэргүүцсэн таван жилийн ойн ухуулгын хөтөлбөр» гэдэг нэгэн бяцхан товхимолыг Х. Лувсанбалдан гуай шинжлэж, «Заяа бандидын зохиосон тод үсгийн үсэг зүйд төдий л их өөрчлөлт ороогүй» [Х. Лувсанбалдан, 1975. х. 68] байсныг ажин тэмдэглэсэн нь дээр дурдсан өөрийнхний саналтай зөрчилтөй болсон ажээ.

XVIII зууны хоёрдугаар хагас бол хүчирхэг том Зүүнгарын төр Манжийн дайлан дагуулагчдад эзлэгдсэн үе байж, тэр нь

зөвхөн дөрвөн ойрдын ард түмний хувь заяанд гамшигт нэгэн үе болсон төдийгүй, соёлынхны үнэт өв, Улс үндэсний бэлгэ тэмдэг болсон тод үсгийн хувьд ч эргэлт гарсан, тодруулбал, төрийн бичгийн хубьд өргөн хүрээнд чөлөөтэй хэрэглэгдэж байсан тод үсэг өөрийн байр сууриа алдсан үе болох ажээ. Гэвч тод үсгийн уг журам нь Зүүнгарын төрийн мөхөлтийг дагалдан тийм түргэн алдагдаж самуураагүй, харин нэлээд урт хугацаанд сонгодог журмаа хадгалсаар байсаныг энэ үетэй холбогдох, он цаг нь тодорхой мэдэгдэж байгаа бичиг дурсгалын зүйлүүд гэрчлэж байна.

XVIII зууны хоёрдугаар хагас хийгээд бүхэл XIX зуун, XX зууны эхний үетэй холбогдох бичиг дурсгалын зүйлийг шүүн үзвэл Шинжаангийн тод үсгийн түүхийн хөгжлийн явцыг түүний үсэгзүй, зөвбичихзүй ба үгийн сангийн онцлогт нь үндэслэн: 1648 оноос XIX зууны сүүл хүртэл нэгдүгээр үе, XX зууны эхнээс мөн зууны тавиад оны эхэн хүртэл хоёрдугаар үе, 1950-аад оноос одоо хүртэл гурвадугаар үе гэж үелэн хуваах нь илүү зохимжтой мэт байна.

Тод үсэг халимагт хэрэглэгдсэн түүхийн явцыг үелэн хуваасан талаар Х. Лувсабалдан гуайн санал харин үнэний үндэстэй бөгөөд XVIII зууны 2-р хагасаас XX зууны эхэн хүртэл ардын дунд аяндаа хэрбэржиж тогтсон заншил бичлэгийг 1915 онд алдарт алтайч В. Л. Котвич нэгэн зүгт нийлүүлэн журамлаж, авиазүйн зарчмаар суурь болгож сонгодог тод үсэгт мэдэгдэхүйц өөрчлөлт оруулсан нь тийм их газар авч чадалгүй, 1924 онд тод үсэг Халимагт бүрмөсөн хэрэглээнээс гарснаар эцэс болгосон ажээ [Номинханов Ц.Д., 1976. х. 52].

В.Л. Котвичийн өөрчлөлт нь голдуу тод үсгийн үсэгзүй хийгээд зөвбичихзүйтэй холбогдсон бөгөөд түүний онцлогийн талаар проф. Д. А. Павлов «В. Л. Котвич и реформа старокальмицкой письменности» [Павлов Д. А., 2000. х. 114 - 129] хэмээх өгүүлэлдээ нарийн өгүүлсэн билээ.

### **1. Нэгдүгээр үетэй холобогдох бичиг дурсгалын зүйл**

**/XVIII зууны дунд – XIX зууны сүүл/**

Дээр дурдсан өөрийн үзэл баримтлалаа батлахын тул энд эрдэмтдийн сайн мэддэг, харьцангуй нарийн судлагдсан эхний зуун жил буюу XVII зууны дунд үеэс XVIII зууны дунд үе хүртэл-

хи дурсгалын зүйлийг энд зориуд заалгүй, харин монгол хэл-шинжлэлтийн сонорт сайн өртгөөгүй, XVIII зууны хоёрдугаар хагас буюу Зүүнгар Хаант Улс Манжид мөхөөгдөсний дараах үе лүгээ холбогдох, он цаг нь тодорхой мэдэгдэж байгаа бичиг дурсгалын зүйлийг заахад доорхи мэт байна: 1) Тэнгэр тэтгэгсэн 20-аар он хөхөгчин гахай /1755/ жилийн зуны дунд сарын сайн өдөр хааны бичсэн «Зүүнгарыг түвшитгэж тогтоосон явдлыг Гэдэн ууланд тэмдэглэн байгуулсан гэрэлт болор чулууны бичиг» [Бадай нар, 1992. х. 396 - 401]; 2) Тэнгрийн тэтгэгсэн 23 - аар он шар барс /1758/ жилийн намрын тэргүүн сарын сайн өдөр хааны бичсэн «Зүүнгарыг түвшитгэж тогтоосны дараа Илийн газарт тэмдэглэн байгуулсан гэрэлт хөшөө чулууны бичиг» [мөн тэнд. х. 402-404]; 3) Зүүнгар Хаант Улсын үед Иль голын хойт эргэнд байгуулсан алдарт Гулза сүмийг эбдэсний дараа Манж хаан энэ сүмийг дураалгаж Халуунаас зайлах ордны зүүн хойт биед (одоогийн Хятадын Хэ бэй мужийн Чэн дэ хот) нэг сүм байгуулаад, Тэнгэр тэтгэгсэн хөхөгчин тахиа /1765/ жилийн намрын дунд сарын шинэ дор хааны бичсэн «Холдахьныг амаржуулагч сүм дор бараалхаж ёсолсон хэргийг тэмдэглэн бичсэн болой» хэмээх хөшөө чулууны бичиг [мөн тэнд. х. 405 - 410]; 4) Тэнгэр тэтгэгсэн 36 -аар /1771/ он зуны сүүл сарын хоринд Тэнгэр тэтгэгч хаанаас Уваш хаанд буулгасан бичиг [Ма Жухэн, 1991]; 5) Тэнгэр тэтгэгсэний 36 -аар он цагаагчин туулай/1771/ жилийн намрын сүүл сарын арван тавдаар хааны бичиж Халуунаас зайлах орднд босгосон «Торгуудын хотол аймаг эээр дагараа ирсэн тэмдэглэл» хэмээх хөшөө чулууны бичиг [Бадай нар, 1992. х. 413 - 420]; 6) Мөн онд босгосон «Торгууд аймгийн улс төр хүнд хэшиг хүртээсэн тэмдэглэл» [мөн тэнд. х. 421-427] зэрэг хөшөө чулууны бичгүүдийг дурдаж болохоос гадна бас XX зууны сүүлийн хориод жилд Шинжаанаас олж илрүүлсэн, он цаг нь тодорхой түүх, шашний зарим дурсгалуудыг зааж болно. Үүнд, Ижлийн ойрдын ихэнхи хэсэг нь 1771 онд хуучин Зүүнгар нутагт буцасны дараа, торгууд ноёдын язгуурт төрсөн тойн гэлэн Dgelson-dgeleds-миоqlдан (Гэлэгчогдон), алдаршсан нэр нь Эжээ хэмээхээр «Илтгэл шаштир шар дэвтэр хийгээд хуучин Ижилд бичсэн хэдэн зүйлийн түүхийн бичгийг дүйлгэн үзэж тэдний дотроос Ижил голоос энд ирж Энхэ амгуулан хаа-

ны цагт орсон Рабжуурын язгуур үндэсэн хийгээд дээд Тэнгэр тэтгэгч богд эзний гучин зургаадугаар онд боолд орсон ноёдын язгуур үндэсн эрхэлэн мөн эдүгээ байсны нь нэмэж гүйцэд тодорхой нарийвчлан бичсэн» гэдэг “Үнэн сүзэгт хуучин торгууд хийгээд чин сэтгэлт шинэ торгууд ногоудын хаан ноёдын уг үндэсний илтгэл түүхийн бичиг буй” [Бадай нар, 1987. х. 375 - 397] хэмээх цагаан торгон дээр бичиж, шар торгоор гадарласан дурсгалын зүйл (энэ уг үндэсний бичигт анх Ван хаанаас аван XX зууны гучаад оны хамгийн сүүлчийн торгууд хаан Манцагжав хийгээд түүний хөвгүүн Гүмбдэжид хүртэлхи торгууд ноёдын уг язгуурыг оруулж бичснээр нь үзэхэд энэ нь наад захдаа XIX зууны сүүл XX зууны эхний үетэй холбогдох дурсгалын зүйл болох нь илхэн байна); «Энэ модон тахиа ... жилийн хоёр сарын арван дөрвөнд Дээди бичиж төгөсгөв» гэдэг төгсгөлийн үгтэй, 1825 онд зохиогдсон гэж эрдэмтдийн тодлсон, XVII зууны эхний үе буюу дөрвөн ойрдын холбоот цэрэг Төвдөд орсон үйл явдлаас 1771 онд «чин зоригт Убаши хаан торгуудын нутгийг дундууры нь тасалж аваад ... хуучин нутаг Иль, Тэкэс» -т ирсэн хүртэлхи түүхэт үйл хэргийг хамарсан «Монголын уг эхэн тууж» [мөн тэнд. х. 314 - 324] хэмээх түүхийн холбогдолтой зүйл; XVII зууны үед модон бараар хэвлэснийг XIX зууны сүүлчээр шинээс модон барт сийлүүлж хэвлэсэн «Хутагт билгийн чанад хүрсэн таслагч очир хэмээх их хөлгөн судар» -ын адил бус хоёр эх зэргийг зааж болно. Тэмдэглэхэд, тус хоёр модон барын сударт Заяа бандидын орчуулсан тухай өөрийнх нь бичсэн төгсгөлийн үг байгаагаас гадна бас хэдийд, хэний санаачлагаар, хэн гэдэг хүн шинээс модон барт сийлсэн тухай нэмэлт төгсгөлийн үг байгаа нь тус бичгийн дахин барлагдсан тодорхой он цагийг мэдэх боломжийг бидэнд олгон өгч бий.

Энэхүү хоёр судрын төгсгөлийн үгийг сийрүүлбэл: уг судрын дугаарлалаар 41 хуудас бүхий нэгэн сударт «*acitu dēdū ilūqsan-ni zarligiyin šime tasuluqci ociriyin keb öüni amitan бүгүдийн Үрбан хорони күлiсү-gi tasulazi dēdū bodhi-dū üdürүdküyin tula, ariun sүзүq tögүsүqsen торyouд хān Buyanmönkü, ēzi fuzin Seridbelyadan köböüd seltetay öqligүйin ezen bolun дүрдүzi asaru kicēngүйitү Urin Geleq Dölēn -nar-yer uralan siyilүүлzi бүтēqsen*» хэмээн тэмдэглэсэн байна. Энд

гарч байгаа торгууд хаан Буянмөнх бол ХХ зууны эхний үеийн хамгийн сүүлийн хаан болох Манцагжавын эцэгэ нь болох бөгөөд ХІХ зууны сүүлчээр амьдарж байсан хүн мөн. Хоёрдугаар судр нь «*ünen süzüqtü Tögös mende amban харin basa modon тулай zildü šine bartu seyilüülbey*» гэсэн төгөсгөлийн үгтэй үүнд модон туулай жил нь 1878 онтой дүйж бий.

Энэ таширамд тэмдэглэхэд, монголч эрдэмтэд сүүлийн үед олдсон ХVІІІ зуун лугаа холбогдох тод үсгийн цөөхөн модон барын сударт үндэслэн дээр үед ойрдууд ном барлах уламжлал тийм өргөн бус байсан ба Зүүнгарын хаанлаг төр мөхсний дараа энэ уламжлал тасарсан гэдэг дүгнэлт хийж байсан нь бодтой байдалтай үл нийцэхийг Шинжаангийн энэхүү шинэ олдбор гэрчлэж бий.

## 2. Энэ үеийн тод үсгийн зарим онцлог

Энэ үеийн тод үсэг нь үсэгзүй, зөвбичихзүй хийгээд үгийн сангийн талаар сонгодог тод үсэг буюу анхны зуун жилд холбогдох бичиг дурсгалын зүйлээс ялгарах зүйл огтхон ч байхгүй байна. Энд дээр заасан бичиг дурсгалын зүйлд тусгагдсан тод үсгийн хэлзүйн зарим онцлогы нь товчхон авч үзвэл:

### Үсэгзүйн талаар:

1) Тод үсгийн олон дуудлагат *z, c* -гээс *j, u* гийгүүлэгч салж гараагүй хэвээрээ байжээ. Жишээ нь: *cināgi, elci ilgēzi, ayiladci, örösözi* г. м. Гэхдээ зарим үгэнд [*zi*] бичих ёстой газар галиг үсгийн [*byi*] хэрэглэсэн нь тохиолдож байна: *жaбыini*.

2) *u, ü* эгшгийн уртыг мөн сонгодог тод үсгийн ёсоор *ou, uu, öü, üü* хэлбэрээр тэмдэглэж байсан байна. Жишээ нь: *Ubuša, Ceqbeq dorzi tanay kezēnē xoucin torγoud urida orosiyin γaza-tu souqsan caqtu; tasuluqci ociriyin keb öüni; öböriyin izdür töröl* г. м.

### Зөвбичихзүйн талаар:

1) Нэр үгийн заахын тийн ялгалын дагаварын *-yigi, -gi* хэлбэртэй нэгэн зэрэг гийгүүлэгчээр төгөссөн үгэнд залгадаг *-i* хэлбэр хэрэглэгдэж байжээ. Жишээ нь: *Odō ta buruu nomi sanal ügey burxani šabyini sanazi ireqsen; Bi ciniy uridaki yabudali sanaxu ügey; yazāγān dayisun ügey, dotorōn xulayay ügey amur tübsin suuxuyigi kicēqtün; ocir dhara-yin xutuγi ötür türgene olxu boltuyay* г. м.

2) Гарахын тийн ялгалын дагаварыг ерөнхийдөө ярианы хэлний ёсоор дээрхи үгтэй нь залгаж *-āsa, -ēse, öso-ōsa* хэмээн бичиж байжээ:

*γazarāsa, orosōso, öünēse, xasaγāsa, noyodōsa* г. м.

3) Монгол хэлзүйчидийн хамтархын тийн ялгал гэдэг, халимаг хэлзүйд нийлүүлэгч гэж нэрлэдэг *luḡā, lügē* дагаварыг дээрхи үгтэй нь залган *-lā, -lē* хэмээн ярианы хэлний ёсоор бичсэн нь энэ үеийн дурсгал бичгүүдэд тохиолдож байгаа нь уридах үеийн дурсгалтай нэгэн адил байна. Жишээ нь: *kerbē urida cimālā dayilalduqsan tere caq tu* г.м.

4) Өх оршхын тийн ялгалын дагаварыг олонхи тохиолдолд дээрхи үгнээс нь салангид бичижээ: *yazar tu, caq tu, xasaq tu, tan du* г. м.

5) Үйлдхийн тийн ялгалын дагаварыг *uzr* хэлбэртэй хамт *sedkilir, zoriyār* гэх мэтчлэн ярианы хэлний хэлбэрийг хэрэглэсэн, мөн сонгодог тод үсэгт дутагдах нөхцөл үйлийн *bolbocu* хэлбэр олонтоо тохиолддог байхад энэ үеийн алван бичигт дурдсан хэлбрийн хамт *bolbocigi* гэсэн хэлбр ч тохиолдож байгаа нь ярианы хэлнээ ойртуулах оролдлогын нэгэн тэмдэг болох нь ил байна.

6) Ерөнхийлөн хамаатуулах дагаварыг тод үсэгт *-bēn, -yēn* хэмээн бичдэгээс гадна дурсгал бичгүүдэд бас *-ān, -ēn, -ōn, -үн* гэх мэтчлэн ярианы хэлний дагуу дээрхи үгтэй нь залгаж бичсэн нь олонтоо тохиолддог. Бидний авч үзэж байгаа энэ үеийн дурсгал бичгүүд ч үүнээс гадуур биш байна. Жишээлбэл: *yazāyān, dotorōn, xōrōn* г.м.

7) Хамаатуулах ёсны гурбадугаар биед хамаатуулах *inu* дагавар мөн идэвхтэй хэрэглэгдсээр байжээ. Жишээ нь: *köbüin inu Zulzaya Örlöq* г. м.

8) Сонгодог тод үсгийн зорих нөхцөл үйлийн *-xā, -kē* дагавар мөн гэр хэвээрээ байжээ. Жишээ нь: *ta barālxaxā ireqsen xoyino bi tan-du kerkim xayiralazi yeke күндү кишиq күртēnē* г.м.

9) Биеийн төлөөний нэрийн нэгдүгээр, хоёрдугаар биеийн харьяалхын тийн ялгалт хэлбрийг тод үсгийн дурсгал бичгүүдэд заримдаа *mini, cini*, заримдаа *miniy, ciniy* гэж бичсэн нь олон тохиолддог үүнд, энэ үеийн дурсгалд хоёрдугаар зүйлийн бичлэг нь зонхилон тохиолдож бий. Жишээ нь: *Bi ciniy uridaki yabudali sansxu ügey; miniy кишиqtü күртекүй-gi кicēqtün* г. м.

10) Үйл үгмйн өнгөрсөн цагийг сонгодог тод үсэгт ихэхдээ *-bay, -bey, -boy, -böy* хэмээн, ирээдүй цагийг *-nay, -ney* хэлбрээр тэмдэглэдэг байхад энэ үеийн дурсгал бичгт *-ba, -bey* хийгээд *-nz* хэлбрээр бичсэн нь тохиолдож байна: *noyodoud sayiduud*

*bügüdertü zarlıq buulyaba; Bi tani бүгүдери өрөшөн айлалда; xasayāsa bāxan cökün künesü abci idezi genē.*

11) Нөхцөл үйлийн болзох хэлбэрийн *-bāsu, -bēsü* дагавар хэрэглэдэг байжээ. Жишээ нь: *a'xan-ēce ödügē kürtelki noyodi cöm güüced niyiliүүлзи bicibēsü; nige nigēn xarazi inaḡ yabubāsu* г. м.

Үгийн сангийн талаар: Энэ үетэй холбогдох дурсгал бичгүүд дээр үеийн дурсгалуудаас ялгарах зүйл байхгүй байна. Гэвч зарим албан бичигт ойрдын хэлний онцлогийг тусгасан үгэс нэлээд тохиолдож байгааг энд жишээлэн үзүүлбэл: *xālyā, yazā, türiüzi, xōrōn, nārān, yamar bese, šoḡ šodor* г. м.

Бидний авч үзэж байгаа энэ үеийн тод үсгийн загвар болгож 1771 оны зуны сүүл сарын хоринд Манжийн Тэнгэр тэтгэгч хаанаас Уваш хаанд өгсөн бичгийг энд галиглан буулгав.

Te'geri-yin kišiq yēr caḡ ezeleqsen

Yeke xān, torḡoud Ubuša, Cebeḡ dorzi, Šēre' bolōd noyodoud sayiduud бүгүдertü zarlıq buulyaba. Ta kedü tümen ulus, buruu nomi sanal ügey. burxani nom sanazi namay temecezi ayišanay gezi manay Iliḡü souqšan anban sayiduud nada ayiladxaqšan. Bi ayiladba. Odō ta buruu nomi sanal ügey, burxani šabyini sanazi ireqšen yeke sayin. Bi tani бүгүдери өрөшөн айлалда. Basa Ubaša, Cebeḡ dorzi, tanay kezēnē xoucin torḡoud urida orosiyin yazar-tu souqšan caḡ-tu tani xān Dondob araši ḡal xulayana zil Tōbödtü elci ilgēzi zougiiyin gegēn-dü cay cinazi nom keyē gezi oros-tu kelezi orosōr nada yuyizi ayiladxaqšan. Bi basa өрөшөн айлалди, tani elci Cobyab biyigi zoudu ilgēzi nom küülüqšen. Odō ta үнен sedkilir burxani nom martal ügey namay temecezi ireqšen tölō odō bi tan-du kišiq kürtēzi өрөшөн айлалду. Basa үүнēse xōrōn ta elci ilgēzi zougiiyin gegēn-dü mörgüzi cay cinazi, nom kiküdü tani zoriyār yabuulxu bišiu. Basa Šēre? ci urida manay cerigi dayilazi orostu odoqšan. Odō ci burxani šabyini sanazi, namay temecezi ireqšen tölō bi ciniy uriduki yabudali sanaxu ügey. Cimāgi oucilan ayiladci өрөшөzi xayiralaxu. Cimay-gi buruušaxu yosun ügey. kerbē urida cimalā dayilalduqšan tere caḡ-tu manay ceriq cimāgi barizi irekülē bi yalalaxu bišiu. Odō ci өбөрөн ireqšen tölō cimadu buruu ügey. Bi cimāgi Ubuša, Cebeḡ dorzi edenē adalı xayiralaxu. Basa ta orosōso nārān yarci xasagi dabiri-zi yabuxudān yabuud xālyadu xasayāsa bāxan cökün künesü abci idezi genē. Tere balay ne? arbitay yuuman biši bolbocigi үүнēse xōrōn ta xasaḡtu šoḡ šodor kel ügey ebtey eyetē sayixan bayiqḡun. Xasaḡ bayituyay ta mön өбөрийн

xōron-du xulayay xudal kel ügey, önöcin öbүүгөн asarazi, miniy kišiqtü kürtekiy-gi kicēqtün. Basa miniy zarliq sonoci, yazāyan dayisun ügey, dotorōn xulayay ügey amur tūbšin suuxuyigi kicēqtün. Basa ta xolo yazarāsa türüzi zobuzi ireqsen. Basa tan-du nutuqlaxu nutuq bolōd yazar usun yamar besēgi Iliyin bya?zi? bolōd anban sayiduudu zakizi zarliq buuliyaya. Ene zabsar-tu ta unā beyēn amuruulzi suucayaqtun. Ta barālaxā ireqsen xoyino bi tandu kerkim xayiralazi yeke күндү kišiq күртөнē. Ta külēzi bayiqtun. Tusxayilan buulyaba.

Te'geri-yin tedkūqsen-ni yucin zuryāduyār on zun-ni süül sarayin xorin

### **3. Хоёрдугаар үетэй холбогдох бичиг баримтын зүйл ба энэ үеийн тод үсгийн онцлог**

XX зууны эхнээс мөн энэ зууны тавиад он хүртэлхи хугацааг бид Шинжаангийн тод үсгийн хоёрдугаар үе гэж үзэсний учир бол энэ үе нь яг сонгодог тод үсгийн уламжлал суларч, шинэ тод үсгийн уламжлал эхлээд бүрэлдэн тогтож байсан шилжилтийн үе болоход оршино. Энэ үеийн тод үсгийн гол онцлог бол сонгодог хэв журам алдагдаж, ярианы хэлний нөлөөгөөр эмх журамгүй бичлэг олширсон ба үгийн сангийн талаар ч их хэмжээний нутгийн аялгууны үг, орос, хятад зээлээ үг зэрэг хэрэглэгдэх болсон явдал болно. Энэ үетэй холбогдох бичиг баримтын зүйл манай гарт тун хумас байгаа боловч энэ үеийн орос, хятадад үүссэн хувьсгалын нөлөөгөөр Шинжаангийн зарим газар ардын сургууль байгуулагдаж, тэнд тод үсэг, монгол, манж хийгээд хятад бичиг зэргийг зааж байсан ба энэ үед Шинжаангийн залуу сэхээтэд тэр үеийн Зөвлөлт Холбоот Улсын Үзбэкийн Бүгд Найрамдах Холбооны Улсын нийслэл Ташкент хотноо Дунд Азийн Их сургуульд ирж орос хэл, тод, монгол бичиг зэргийг тэнд багшилж байсан Ц. Д. Номинханов, А. Сусеев зэрэг халимаг эрдэмтэн багш нараас сурч байсан ажээ. Мөн энэ үед Халимагийн эрдэмтэй лам Шинжаанд хүрч суурьшин сууж, тэндхийн зарим сургуульд В. Л. Котвичийн өөрчлөлт оруулсан тод үсгийг зааж байсан ба түүний энэ ажиллагаа нь Шинжаангийн зарим бичиг тамгатай эрдэмтэн лам нарын эсэргүйцэлд учирж байжээ. Иймээс энэ үеийг халимагийн тод үсэг, өөрөөр хэлбэл 1915 онд В. Л. Котвичийн өөрчлөлт оруулсан тод үсэг Шинжаангийн тод үсгийг нөлөөлж эхэлсэн үе гэж үзэж болмоор юм. Ташкент хотноо су-

ралцаж байсан тэдгээр сэхээтэд хожим нь нутагтаа буцаж олонхи нь сургууль, хэвлэлийн газар ажиллахдаа халимаг багшаас сурсан зүйлээ бодит үйлдлэгдээ хэрэглэж байсан гэдгийг таамаглахад бэрхтэй биш байна. Ц.Д. Номинхановын тод үсгийн конспект гэж нэгэн гар бичмэл тэмдэглэл Шинжаангийн ууган сэхээтдийн нэг, тавиад онд тод үсгийн заан сургалтын ажил хийж байсан, “Жангар” цуглуулаач бөгөөд жангарч, судлаач Т. Бадмын гарт сүүлийн үе хүртэл хадгалагдаж гарын авалга болж байсан юм. Гэвч дөчөөд онд Шинжаанд гарч байсан нэгэн “Долоон сарын долооны хариуцах дайлдааны тавдагч жилийн тархаалын их хэлхээ” гэдэг хэвлэлийн зүйлийг Х. Лувсанбалдан шинжлэж бичихдээ: “Энэ бяцхан товхимолын байдлаар үзэхэд Зая бандидын зохиосон тод үсгийн үсэг зүйд төдий л их өөрчлөлт ороогүй боловч хятад үг, Шинжааны Ойрдын аялгууны үг өдий төдий орсон байдал харагдаж байна” хэмээн тэмдэглэсэн билээ [Х. Лувсанбалдан, 1975. х. 68]. Иймд энэ үеийн тод үсгийн онцлогийн талаар доорх мэтийн дүгнэлт гаргаж болмоор байна:

Үсэгзүйн талаар энэ үед олон дуудлагат z, c -гээс j, ç гийгүрлэгч арай салж амжаагүй байжээ. Жишээ нь: itegemzi, kücin, dëremcin г. м. Хэлзүйн нөхцөлийг бичих талаар ч онцын хувиралт ороогүй байсан боловч ярианы хэлнд үндэслэсэн зарим бичлэг харагдаж бий. Жишээлбэл, zorigiyigi гэж бичих ёстойг zörgi, orkïd гэж бичхийг orkād, ider хэмээхийг yedür, dayilalduzi гэхийг daildazi гэх мэтчлэн бичсэн зүйлийг зааж болно. Мөн энэ үеийн зарим хэвлэлийг авч үзвэл зөвбичихзүйн талаар нэгдэлтэй журамд орж амжаагүй байж, ярианы хэлний дагуу бичсэн дүрэм бус бичлэг зонхилж байсан ба үгийн сангийн талаар ч нийт монгол бичгмйн хэлнээс ялгавар бүйхий (сонгодог тод бичгийн хэлтэй харьцуулбал) нутгын үг хийгээд орс, хятад хэлний нөлөө ч мэдэгдхүйц байсан нь харагдна. Жишээлбэл, 1957 онд Үрэмч хотноо хэвлэгдсэн бага сургуулийн гуравдугаар ангид үзэх «Арифметикийн бодлого» сурах бичгийн зүйлд хэлзүйн нөхцөлүүдийг нэгдэлгүй бичсэн, зөвбичлэгийн талын ташаа зүйл зөндөө харагдаж байсныг цөөхөн жишээгээр үзүүлбэл: -qtan/-qten (-qtun/-qtün гэж бичихийг): oloqtan, üzüüleqten, zokbqtan, zuruqtan, xubāqtan, abaqtan; -bay/-bē, -ba (-bay/-bey хэмээн бичхийг): baribay, irebē, xadaba, nemeqdebē; Урт эгшгээр бичих ёстой газар

хос эгшгээр бичсэний жишээ нь: хогоi (хогō гэж бичихийн оронд), хор᠑oi (хор᠑ō гэж бичихийн оронд), širei (širē гэж бичихийн оронд), teikūlei (teigekūlē гэж бичихийн оронд); Асуух сул үгийг зарим газар боi хэмээн бичгийн хэлний дагуу, зарим газар вз гэж ярианы хэлний дагуу нэгдэлгүй бичсэн; зарим орон нутгын онцлог бүхий үг хэллэг /кийлэн, ойох, тунгурцаг г. м./ хэрглэсэн байдал харагдаж байгаагаас гадна бас “паравоз, пионер, пүүз, янйүү” гэх мэтийн орс, хятад зээлээ үг ч үлэмжхэн хэрэглэгдэж байжээ. [Х. Лувсанбалдан, 1975. х. 68].

#### **4. Гуравдугаар үеийн тод үсэг, түүний онцлог**

XX зууны тавиад оны сүүлчээс Шинжаангийн тод үсгийн гуравдугаар үе буюу орчин үе эхлэн одоо хүртэл үргэлжилж байгаа бөгөөд энэ үе нь тод үсгийн хэрэгцээ урьд өмнөх аль ч үеээс илүү шаардагдах болсон, тод үсгийг сургууль соёлын газар өргөнөөр зааж сургах болсон, тод үсгээр албан хэвлэл их хэмжээгээр хэвлэгдэх болсон үе болно. Өөрөөр хэлбэл энэ үе бол тод үсэг Шинжаангийн Ойрдын үндэсний бичиг болохыг ойрдын тусгаар тогтосон төр мөхсний дараа шинэ нөхцөлд албан ёсоор батласан үе болох юм.

1949 онд Хятадад шинэ байгуулал эхлэн тогтож, олон үндэстнүүд тус тусын хэл бичгээрээ сонин хэвлэл эрхлэх, сургууль соёлын газар ихээр эрхлэх болсон учир тод үсгийн хэрэгцээ ч их болж, эмх замбараа нь алдагдсан тод үсгийг журамлаж, нэгдэлтэй дүрэм горим тогтоох ажил шаардагдах болсон ба ийм оролдлогыг тэр үеийн бичиг тамгатай сэхээтэд, тэдний дотор Ташкент хотноо Төв Азийн Их сургуульд суралцагчид хамтран хийж эхэлсэн ажээ. Ийм оролдлогын дунд 1953 жилийн 6 сард Үрэмч хотноо одоо хүртэл хүчинтэй байсаар байгаа “Монгол хэлний дүрэм” хэмээх тод үсгийн хамгийн анхны тусгай дүрэм хэвлэгдсэн ажээ. Энэ “Дүрэм” нь орчин цагийн тод үсэг ба түүний зөвбичихзүйн суурь болсон юм. Тэмдэглэх нэгэн зүйл бол тус “Дүрэм” нь тогтоогдсон тэр үе ба түүний хойно арав шахам жил нийтэд хүлээн танигдаж, түгээмэлжиж чадаагүй байсан учир 1957 онд гарсан зарим хэвлэлд ч тогтоосон дүрмээс гадуур, нэгдэлгүй бичлэг мөн оршсоор байсныг дээр заасан “Арифметикийн бодлого” –оос мэдэж болмоор юм.

Орчин цагийн Шинжааны ойрдын тод үсэгт Заяа бандидын

зохиосон долоон эгшиг үсэг, төрөлхи хэлний уугал үгсийг тэмдэглэхэд хэрэглэдэг байсан 14 төрөл, 16 зүйлийн гийгүүлэгч үсэг, мөн хоёр цул дэвсгэр үсгийг бараг өөрчлөлт оруулалгүй тэр хэвээр нь авч хэрэглэхдээ, *z, j* хоёр ба *c, u* хоёрыг салгаж, уг нь энэ дөрвөн авиаг тэмдэглэж байсан хоёр тэмдэгтээр зөвхөн *z, c* хоёрыг л тэмдэглэх болгож, *j* хийгээд *u* -г тод үсгийн галиг дотроос хоёр тэмдэгтийг шилжүүлэн авч тус тус тэмдэглэх болгожээ. Ингэж өөрчлөсний дүнд тод үсгийн зөвбичихзүйг зарим талаар аман ярианд улам ойртуулсан ажээ.

Энэтхэгийн 50 үсэг, Төвдийн 30 үсгийг галигладаг тод үсгийн галиг нь орчин цагийн хэрэгцээнд тийм өргөн шаардагдахгүй болсноор тэр бүгдий нь авалгүй, зөвхөн орчин үед онцын хэрэгцээтэй гэж үзсэн таван галиг үсгийг авч үүний дээр ялангуяа хятад хэлнээ байнга хэрэглэгддэг дээд шүд доод урулын хамжин шүргэх [f] авиаг тэмдэглэх тэмдэгтийг шинээр нэмж зохиогоод, сонгодог тод үсэгт гийгүүлэгч үсгийн бүрэдэхүүнд орж байсан эр үгийн [ka] үсгийг галиг үсгийн тоод оруулж, уг нь галиг үсгийн бүрэлдхүүнд байсан бүслүүрт [pha] -г харин гийгүүлэгчийн бүрэлдэхүүнд оруулжээ.

Хэлзүйн талаар орчин цагийн тод үсэгт нэр үгийн тийн ялгал, оln тоо, хамаатуулах ёсны дагаварууд, үг хувилгах, бүтээх арга тэргүүтнийг бараг онцын хувиралт оруулалгүй тэр хэвээр нь авч хэрэглэсэн боловч угын үгзүй-гаралзүйн зарчмыг авиазүй-үгзүйн зарчим болгон өөрчлөснөөр онцлог болгоно.

**Тийн ялгалын талаар:** Орчин цагийн тод үсэгт сонгодог тод үсгийн харьялахийн тийн ялгалын дагаваруудыг бүхэлд нь авч хэрэглэхдээ, эгшигээр төгссөн үгэнд залгадаг сонгдог тод үсгийн урт шүд + шилбэ бүтэц бүхий [-yin] хэлбэрийг богино шүд + шилбэ бүхий [-in] хэлбэрээр бичих болгосон ба сонгдог тод үсэгт харьялахийн тийн ялгалын дагаварыг мөр шилжүүлэхээс бусад тохиолдолд бүр үгийн үндэстэй нь залгаж бичдэг байсныг салгаж, залгаж алинаар нь ч бичиж болох болгожээ. Жишээлбэл: sarayin –sara-in ~ sarain, nomiyn – nom-in ~ nomiin, oyirodiyin – oirad-in ~[oiradiin гэх мэт.

Заахын тийн ялгалын талаар, сонгодог тод үсэгт тус дагаварыг ихэнхдээ монгол бичгийн дагуу [-i] буюу [yi] хэмээн, зарим тохиолдолд [-yigi] (энэ хэлбрийг бүх тохиолдолд үгийн үндэстэй нь залгаж бичдэг байжээ) гэхчлэн бичдэг байсаныг яри-

аны хэлний дагуу бүх тохиолдолд [igi], [gi] гэж бичих болгоходоо мөн салгаж залгаж алинаар нь ч бичиж болх болгожээ. Жишээлбэл: kümüni – kümüti ~ kümü-igi, šajini – šajiniigi ~ šajin-igi, boluxuy – bolxuiigi ~ bolxu-igi гэх мэт.

Гарахын тийн ялгалын ёсе дагавартай нэгэн зэрэг сонгодог тод үсэгт āsa, ēse, ōso, ösö гэж ярианы хэлний дагуу бичдэг байсаныг орчин цагийн тод үсэгт ёсе хэлбэрийн дээр харин āsu, ēse хоёр хэлбэрээр, эгшиг зохицлын дагуу бичих болжээ. Жишээлбэл: nutuāsa - nutuāsu, dotorēōso - dotorōsu.

Ерийн байдалд үйлдэхийн тийн ялгалын дагаварыг [bēg], [yēg] хэмээн сонгодог тод үсгийн адил бичиж байгаа боловч, үүний зэргэд бас ярианы хэлний дагуу [āg], [ēr], [ōg], [ōg] хэлбрийг ч үргэлж хэрэглэх болжээ.

Сонгодог тод үсэгт хамтархын тийн ялгалын дагаварыг [tay], [tey], [toy], [tōy] хэмээн чанга, хөндийн зохицол ба уруулын зохицолд суурилан бичдэг байсныг уруулын зохицлоор бичих хэлбрийг орхиж, эхний хоёры нь л чанга хөндийн зохицлоор хэрэглэх болсон байна. Харин [luā], [lūgē] дагаварыг тод үсгийн дурсгалын зүйлд ярианы хэлний дагуу la/lē хэлбэрээр тэмдэглэсэн нь ч хаяа тохиолддог [X. Лувсанбалдан, 1975. х. 51] байхад, орчин цагийн тод үсэгт уг luā, lūgē хэлбэрээр нь хэрэглэж бий.

Олон тоо заах дагаварын талаар: Орчин цагийн тод үсэгт сонгодог тод үсгийн nogoud хэлбэрээс бусад -d, -s, nar/ner зэрэг дагаварыг хэрэглэж бий бөгөөд, үүнд nar нөхцөлийг үгийн үндэсэнд залгаж, салгаж бичиж бүр болдог ба салангид бичсэн тохиолдолд эгшиг зохицох ёсыг зөрчиж, эм үгийн хойно ч nar бичиж болдог байхад, ner нөхцөлийг хэзээд үгийн үндэсэнд залгаж, эгшиг зохицолын дагуу бичдэг. Жишээлбэл: axanar, baqši-nar, nököd-nar, düüner, gišiner гэх мэт. Сонгодог тод үсэгт тус дагаварыг чанд эгшиг зохицох ёсыг баримтлан үгийн үндсэнд нь ихэнхдээ залгаж бичдэг журамтай байжээ. Жишээлбэл: te'geriner, yirtüncüner, nayizinar гэх мэт.

Үйл үгийн хувилалын талаар: Орчин цагийн тод үсэгт үйл үгийн нөхцөл хийгээд түүнийг залгах ёсыг бараг сонгодог тод үсгийн ёсоор авч хэрэглэсэн боловч, зарим талын өөрчлөлт оруулсан нь голдуу i эгшигээр төгссөн үйл үгийн

үндсэнд урт эгшгээр эхэлсэн дагавар залгахад, уг сонгодог тод үсгийн үгийн үндсийг чанд хадгалан бичдэг ёсыг зөрчиж, зарим тохиолдолд үгийн үндсийг эвдэж, ярианы хэлний дагуу бичдэг болсон лугаа холбогдно. 1953 оны 3-р сард Үрэмч хотноо хуралдсан Шинжаангийн монгол хэлний эрдэм шинжилгээний хурал дээр тод үсгийн зөвбичихзүйн асуудал хэллэлцэж, *i* эгшгээр төгссөн чанга үгийн үндсэнд урт эгшгээр эхэлсэн дагавар залгахад үгийн үндсийг эвдэлгүй хэвээр нь үлдээж, хөндий үгэнд үгийн үндсийг эвдэж бичих нь зүйтэй гэх санал гарч байсан [X. Лувсанбалдан, 1975. х. 44] нь сүүл сүүлдээ мөрдөж бичих зарчим болсон байна.

а) «*i*» эгшгээр төгссөн үйл үгийн үндсэнд урт эгшгээр эхэлсэн /урьдчлах нөхцөл үйлийн [ād], [ēd], [ōd], [öd], захирах хүсэх хэлбрийн [-uul]/ [-üül], үйлээс нэр бүтээх [-uur]/ [-üür]; [āci], [ēci], [ōci], [öci]; [āsun], [ēsün], [ōsun], [ösün] зэрэг дагаварыг чанга үгэнд залгахад үгийн үндсийг эвдэлгй бичиж, хөндий үгэнд үгийн үндсийг эвдэн бичиж бий. Жишээлбэл:

solī= solīd, solīsun, soliuł;  
orki= orkid, orkiul;  
bari= barīd, barīci, bariul;  
xari= xarīd, xariul;  
tabi= tabīd, tabiur;  
tülki= tülkēd], tülküür, tülküül;  
küli= külēsün, külüül; külēd;  
biçi= bičēci, bičüür, bičüül.

Гэхдээ xariul, tabiur гэх мэтээр чанга үгэнд урт -u эгшгээр эхэлсэн дагавар залгахад, дээр үеийн тод үсэгт чанга үгэнд *i* –ийн дараа орсон *u* эгшигт “уруу татаас” хэмээх ялгах тэмдгийн зүйлийг үл тавьдаг байсан бол, XIX зууны дунд үеэс хойш ялгах тэмдэгтэй бичих болсон [А. Попов, 1847] нь орчин үеийн тод үсгийг ч нөлөөлжээ. Үнэндээ энэ нь эгшиг зохицох ёсонд холбогдох зүйл болох учир ялгах тэмдэг тавьхын ямарч шаардлага байхгүй юм.

б) «-u/-ь» эгшгээр төгссөн үйл үгийн үндсэнд урт -v/-з/-б/-ө эгшгээр эхэлсэн дагавар залгахад, сонгодог тод үсэгт мөн үгийн үндсийг үл эвдэн бичдэг байсан бол орчий үед авиазүйн зарчмаар үгийн үндсийг нь эвдэж бичих болжээ. Жишээлбэл: yabu=

> yabūd (сонг.), yabād (орч.), mörgö= >[mörgöci] (сонг.), [mörgēci] (орч.).

Үүнээс гадна бас зарим нэр үгийн үндсийг ч дурдсан нөхцөлд эвдэж бичих болсны жишээ нь: [tabu(n)] – [tabūd] (сонг.), [tabād] (орч.) болно.

в) Сонгодог тод үсэгт “-ji, -ci, -ši” үеэр төгссөн үйл үгийн үндсэнд урт -ы эгшгээр эхэлсэн дагавар залгахад, үгийн үндсийг эвдэлгүй бичдэг байсныг орчин үед харин ярианы хэлний дагуу үгийн үндсийг нь эвдэж бичих болгосон нь: [bayaji=] – [bayajuul], [biči=] – [bičüül], [u᠋᠋ᠰi=] – [u᠋᠋ᠰuul].

Үгийн сангийн талаар ойрдын нутгийн үг хэллэгээс гадна монгол бичгийн хэлний үгс, ялангуяа монгол хэлний нэр томьёо өргнөөр хэрэглэгдэх болсон нь сүүлийн үеийн тод үсгийн гол онцлог болно.

#### Ном зүй

Бадай, Алтаноргил, Эрдэни. Ойрд түүхийн дурсгалууд. Үрэмчи, 1992.

Бадай, Алтаноргил, Эрдэни. Ойрд түүхийн сурвалж бичиг. Үрэмчи, 1987.

Лувсанбалдан Х. Тод үсэг, түүний дурсгалууд. Улаанбаатар, 1975.

Ма Жухэн, Ма Дачжэн. Пяо ло и юй дэ минь цзу –XVII чжи XVIIIши цзи дэ ту эр ху тэ мэн гу. Бэй цзин, 1991 (Народ, скитающийся на чужбине –Торгуты в XVII – XVIII в., фото приложения № 5. Пекин, 1991).

Монгол хэлний дүрэм. Үрэмчи, 1953.

Номинханов Ц. Д. Очерк истории калмыцкой письменности. М., 1976.

Павлов Д. А. Вопросы истории и строя калмыцкого литературного языка. Элиста, 2000.

Попов А. Грамматика калмыцкого языка. Казань, 1847.